



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/372

Улаанбаатар хот

Хөрөнгө хуваарилах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>б</sup> дугаар зүйлийн 21<sup>б</sup>.2, Эрүүл мэндийг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоол, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан орон нутагт, нийслэлд нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор Эрүүл мэндийг дэмжих сангаас зарцуулах хөрөнгийн хуваарийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хуваарилагдсан хөрөнгийг зохих журмын дагуу орон нутаг, нийслэлд шилжүүлж, хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Д.Төмөртогтоо/, Эдийн засаг, санхүүгийн хэлтэс /Б.Пүрэвсүрэн/-т тус тус даалгасугай.

3. Тус хөрөнгийг хүн амыг урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн үйл ажиллагаа”-ны хэрэгжилтийг хангахад үр дүнтэй зарцуулж үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг 12 дугаар сарын 01-ний дотор тус яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

081091

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 09-ны өдрийн  
А. 1342 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**Эрүүл мэндийг дэмжих сангаас зарцуулах хөрөнгийн хуваарь  
(Орон нутаг, дүүрэг)**

№	Аймаг, дүүргийн нэрс	Хуваарилагдсан хөрөнгө, сая/төгрөг
1	Архангай аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
2	Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
3	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
4	Булган аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
5	Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
6	Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
7	Дархан-уул аймгийн Эрүүл мэндийн газар	13 000 000 төгрөг
8	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
9	Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
10	Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
11	Завхан аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
12	Орхон аймгийн Эрүүл мэндийн газар	13 000 000 төгрөг
13	Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
14	Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
15	Увс аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
16	Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
17	Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
18	Төв аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
19	Ховд аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
20	Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
21	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
22	Нийслэлийн эрүүл мэндийн газар	8 000 000 төгрөг
23	Багануур дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг

24	Багахангай дүүргийн ЭМТ	5 000 000 төгрөг
25	Баянгол дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг
26	Баянзүрх дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг
27	Налайх дүүргийн ЭМТ	5 000 000 төгрөг
28	Сонгинохайрхан дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг
29	Сүхбаатар дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг
30	Хан-Уул дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг
31	Чингэлтэй дүүргийн ЭМТ	8 000 000 төгрөг
<b>НИЙТ ДҮН</b>		<b>252 000 000 төгрөг</b>

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 04-ны өдрийн  
А. дугаар тушаалын 2 дугаар хавсралт  
1342



## АЖЛЫН УДИРДАМЖ

### Үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын сангийн тухай хуулийн 21<sup>8</sup> дугаар зүйлийн 21<sup>8</sup>.2-т сангийн хөрөнгийг “Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” /21<sup>8</sup>.2.1-2.7/ гэж заасан заалтын дагуу нийт хүн амд хүрч ажиллах, эрүүл аж төрөх ёсыг сурталчилах, зан үйлийг төлөвшүүлэх зорилготой.

Тус яамнаас 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа хэдий ч орон нутаг болон эрүүл мэндийн байгууллагад санхүүжилт дутмаг байсаар байна. Эрүүл мэндийг дэмжих санд хүсэлт ирүүлсэн 21 аймаг болон эрүүл мэндийн байгууллагуудын саналыг харгалзан үзэж “Эрүүл мэндийг дэмжих сан”-гийн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг аймаг, дүүрэгт хуваарилж байна.

**Зорилго:** Нийт хүн амыг эрүүл мэндийн шинэ мэдээ, мэдээлэлээр хангах, мэдлэг олгох, эрүүл аж төрөх, зан үйлийг сурталчилах, төлөвшүүлэх, сургалт явуулах

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх:
  - 1.1. Архи, тамхины хор хөнөөл,
  - 1.2. Эрүүл бус хооллолт,
  - 1.3. Хөдөлгөөний дутагдал.
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх:
  - 2.1. Сүрьеэгийн халдвар,
  - 2.2. БЗДХ болон тэмбүүгийн халдвар,
  - 2.3. Хепатит В вирусийн халдвар.
3. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх
4. Эмийн зохистой хэрэглээ
5. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах
6. Эх, нялхсын эндэгдэлээс урьдчилан сэргийлэх:
  - 6.1. нөхөн үржихүйн эрүүл мэнд,
  - 6.2. перинаталь болон төрөлхийн хөгжлийн гажигийг эрт илрүүлэх

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх
2. Нийт хүн амд сүүлийн үеийн техник, технологи, олон нийтийн сүлжээ зэргийг ашиглан үр дүнтэй мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, түгээх
3. Хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцох, тайлан мэдээ гаргах
4. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт тогтсон хугацаанд ирүүлэх

**Явцын хяналт, үнэлгээ:**

Улирал тутамд үнэлгээг хийнэ. Эрүүл мэндийн сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллана.

**Хариуцах байгууллага:** 21 аймгийн ЭМГ, Нийслэлийн эрүүл мэндийн газар, 9 дүүргийн ЭМТ

**Хамтран ажиллах байгууллага:** ЭМЯ, бусад холбогдох байгууллагууд

**Санхүүжилт:** Эрүүл мэндийг дэмжих сан

**Хугацаа:** 2017-2018 он

**Хүлээгдэж буй үр дүн:**

1. Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа хэрэгжсэн байна
2. Мэдээ, мэдээллийн сүүлийн үеийн техник, хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашигласан болон нийт хүн амд хүрч ажилласан байна.
3. Нийт ард иргэд өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар шинэ, мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаагаар хангагдсан байна.
4. Эрүүл аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлж эхэлсэн байна.